



**ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ
ХУВЬЦААТ КОМПАНИ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
1 дүгээр хороо, Жигжиджавын гудамж 8, Финанс төв
Утас: 7505-5555

И-мэйл: info@erdenestt.mn, Вэбсайт: www.ett.mn

᠒᠐᠒4. 10. 31 № ᠒1/᠒305
танай _____-ны № _____-т

**ТЕНДЕРТ ОРОЛЦОХЫГ
СОНИРХОГЧ ЭТГЭЭДҮҮДЭД**

Тодруулга хүргүүлэх тухай

Тус компаниас зарласан ЭТТХК/20240103136 дугаартай "Катерингийн үйлчилгээ (Уурхай, НБҮ, ТНАЛТ)" үзүүлэгчийг сонгон шалгаруулах тендерт Монополын эсрэг газарт тендерт оролцохыг сонирхогч этгээдээс гомдол гарсны дагуу тус гомдлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу хянаж 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 01/1770 дугаартай "тендерийн баримт бичиг хянасан тухай" албан бичгийг ирүүлсэн.

Тус "тендерийн баримт бичиг хянасан тухай" албан бичигт "Захиалагч тендерийн баримт бичгийн ТШЗ 19.1.1-д "Үйлчилгээ үзүүлэх хүний нөөц "Шаардана", Багц тус бүрд "Технологич-2, Хүнсний технологич мэргэжилтэй, Хүнсний эрүүл ахуйч-2, Хүнсний технологич эсхүл хүнсний эрүүл ахуйч мэргэжилтэй" гэж тус тус заасан байна.

Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/146 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх мэргэжлийн чиглэл, /хөтөлбөрийн нэр/, индекс"-д "07 Инженерчлэл, үйлдвэрлэл, барилга байгууламж, 072 Үйлдвэрлэл, боловсруулалт, 0721 Хүнс боловсруулалт, 072101 Хүнс судлал, 072102 Хоол зүй, шим судлал, 072103 Хүнсний чанар, аюулгүй байдал, 072104 Хүнс үйлдвэрлэлийн технологи, 072105 Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний технологи" гэж тус тус заасан байна.

Тендерийн баримт бичгийн ТШЗ 19.1.1-д Технологич-2. Хүнсний технологич мэргэжилтэй, Хүнсний эрүүл ахуйч-2. Хүнсний технологич эсхүл хүнсний эрүүл ахуйч мэргэжилтэй" гэж заасан нь Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/146 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх мэргэжлийн чиглэл, /хөтөлбөрийн нэр/, индекс"-д нийцэхгүй байх тул эдгээр шалгуур үзүүлэлтүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 17 дугаар зүйлийн 17.2.3 дахь заалтад заасныг тус тус зөрчсөн гэж үзэх үндэслэл байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.5.2 дахь заалтыг үндэслэн тендерийн баримт бичгийн ТШЗ 19.1.1-д холбогдох өөрчлөлтийг оруулж хэрхэн шийдвэрлэсэн талаар эргэж мэдэгдсэний үндсэн дээр тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэн явуулахыг даалгаж байна." гэсэн байна.

Иймд Монополын эсрэг газраас ирүүлсэн 01/1770 дугаартай "тендерийн баримт бичиг хянасан тухай" албан бичгийг дагуу тендерийн баримт бичигт дараах өөрчлөлтийг оруулж байна. Үүнд:

1124044260

ТШЗ-ны холбогдох заалт	В. ТЕНДЕР БЭЛТГЭХ					
ТШЗ 19.1.1	Техникийн чадавх болон туршлагын шаардлага: "Шаардана"					
	1. Үйлчилгээ үзүүлэх хүний нөөц: "Шаардана"					
	Багцын дугаар	Албан тушаал	Тоо	Мэргэжлээрэй ажилласан жилийн туршлага	Мэргэжил	Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/46 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх мэргэжлийн чиглэл /хөтөлбөрийн нэр/, индекс"
	Багц 1, Багц 2 /Багц тус бүрд/	Технологич	2	3 болон түүнээс дээш жил	Хүнсний технологич, Хүнс үйлдвэрлэлийн технологи, Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний технологи	072104, 072105
		Ерөнхий тогооч	2	3 болон түүнээс дээш жил	Хоол үйлдвэрлэл үйлчилгээний технологич, Хүнс үйлдвэрлэлийн технологи, Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний технологи	072104, 072105
Менежер, зохион байгуулагч		2	3 болон түүнээс дээш жил	Бакалавр эсхүл түүнээс дээш зэрэгтэй, дээд мэргэжилтэй байх	-	
Хүнсний эрүүл ахуйч		2	3 болон түүнээс дээш жил	Хүнсний технологич эсхүл хүнсний эрүүл ахуйч, Хүнс үйлдвэрлэлийн технологи, Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний технологи, Хүнсний чанар, аюулгүй байдал	072103, 072104, 072105	
Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ						
ТШЗ 26.1.	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр Цаг: 09 цаг 00 минут Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийн материал хүлээн авах боломжгүй.					
ТШЗ 26.2.	Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна. Огноо: 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр Цаг: 09 цаг 30 минут Тендер нээх газрын хаяг: "Эрдэнэс Таван толгой" ХК, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын-8 Финанс төв, 5-р давхар, 502 тоот, Улаанбаатар хот-15160, Монгол Улс					

- Нэгдүгээр хавсралтаар шинэчилсэн ажлын даалгавар
- Хоёрдугаар хавсралтаар тендерт оролцохыг сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулгын хариуг хүргүүлж байна.

Дээрх тодруулга нь тендерийн баримт бичгийн салшгүй нэг хэсэг болно.

Хавсралт хуудастай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Х.МӨНХЖАРГАЛ